



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

118 дугаар байшин, Залуучуудын гудамж-1, 3 дугаар баг,  
Сайншалан сум, Дорноговь аймаг, 44103,

Утас: (976) 7052 3998

Цахим хуудас: [dornogoviy@zavag.gov.mn](mailto:dornogoviy@zavag.gov.mn)

№25. 01. 03 № 05

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА А.ЭНХМАНЛАЙ ТАНАА

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий  
төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг  
холбогдох хавсралтын дагуу гаргаж хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай



ДАРГЫН ҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ОЛЗБАЯР

4425030002

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжүүлэх хугацаа | Зорилгот түвшин   | 2024 оны хэрэгжилт   | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | Хэрэгжилтийн хувь |
|-----|--|---------------------|---|--|---------------------------------------|-------------------|
| 1   | 2  | 3                   | 4   | 5  | 6                                     | 7                 |
| 1   | Бэлчээрийн нөөц боломжийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг сайжруулан эрчимжүүлэх, уламжлалт бэлчээрийн улирлын хуваарийг зохиостой байлгаж, бэлчээрийг усжуулах, доройтлоос хамгаалах, цаг агаарын хүндрэлтэй үед ашиглах отрын бүс нутгийг тогтоох зэргээр бэлчээрийн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 2015-2027           | Бэлчээрийг доройтлоос хамгаалах, отрын бүс тогтоосон байна. | Бэлчээрийг сэлгэн ашиглах, өнжөөж амрах арга хэмжээний төлөвлөлтөөр Алтанширээ - 423902.7 га, Замын-Ууд 5500.0000га Мандах- 962957.6901га, Өргөн 293222.8839 га Улаанбадрах 397229.9821га Хөвсгөл 282709.4959 га Эрдэнэ 320638.2109 га газрыг сумын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгаж, 194 өрхийн 122.9 мянга орчим толгой малыг 2024 оны 06 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд сэлгэж ашигласан. Бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолоор 6 сумын нийт 108.9 мянган га бэлчээрийн газрыг "Сум дундын отрын нөөц нутаг"-аар тогтоож, 5 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Дээрх отрын нөөц нутгуудад бэлчээрийн ургац 0.4-3.1 ц/га хэмжээтэй байх үед хонин толгойд шилжүүлснээр 64263 толгой мал өвөлжиж, хаваржиж ба 2023-2024 онд Сайхандуулан, Мандах, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын 34 өрхийн 40.8 мянган толгой мал отроор өвөлжиж, хаваржиж хүндрэлийг эрсдэл багатай даван туулсан. Мөн Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын нийт 30 мянган/га бэлчээрийн талбайд 2023 онд бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй үлийн цагаан оготготой байгаль орчинд халгүй энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг тухайн сум орон нутгийн 133 малчин, мал бүхий иргэдийг хамруулан зохион байгуулсан. Тус ажлыг зохион байгуулснаар бэлчээрийн талхалдлыг багасган, бэлчээрийн ургамлын нөхөн ургах боломжийг бүрдүүлж хонин толгойд шилжүүлснээр 6.9 мянган толгой малыг бэлчээрлүүлэх боломж бүрдсэн. Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн намырн хортон мэргэчин тодотгох судалгааг 2.6 сая га бэлчээрийн талбайд хийж тэмцэх хэмжээний биш гэсэн дүгнэлт гарсан тул 2024 онд үлийн цагаан оготготой тэмцэх ажил хийгдээгүй. | 48.0 сая                              | 100               |
| 2   | Бэлчээрийн усан хангамжийн бэлчээрийг усжуулах арга хэмжээ авснаар бэлчээрийн нөөцийг 1667299,85 га-гаар нэмэгдүүлсэн  | 2015-2027           | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлсэн байна.              | Улсын төсвийн 94,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайхандуулан, Эрдэнэ сумдад шинээр 3 инженерийн хийцтэй худал, аймаг ОНТ-ийн 147,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хатанбулаг суманд 3 инженерийн хийцтэй худал, Өргөн, Даланжаргалан сумдын ОНХС-ийн 271,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 гүний цоонг, малчдын санаачилгаар Айраг, Иххэт, Сайншанд, Өргөн, Мандах, Сайхандуулан, Хатанбулаг, Эрдэнэ сумдад инженерийн хийцтэй 3 худал, 9 энгийн уурхайн худгийг шинээр, 18 энгийн уурхай худгийг сэргээн засварласан. Шинээр 29 худгийг ашиглагдах оруулснаар 40 мянган га бэлчээрийг усжуулж, 98 мянган толгой малыг услах боломж бүрдсэн.  | 512.8 сая                             | 100               |

Ц. Г. 100

|   |  |           |  |   |           |      |
|---|--|-----------|--|---|-----------|------|
| 3 | Хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангахад төлөвлөлт  | 2015-2027 | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна        | Усалгаатай газар тариалангийн төлөвлөлтөөс 7 нэгж талбарын 0.7 га газрыг сумдын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгаж сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын 2024 оны оны 04 дүгээр сарын 03 өдрийн 136 дугаар тогтоолоор батлуулсан. Усалгаатай газар тариалангийн 5 нэгж талбарын 0.5 га газрыг зарыг сумын Засаг даргын шийдвэрээр олгоод байна. Дорноговь аймаг 2024 онд Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, бусад ашиг таримлын үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд нийт 217.3 га-д тариалалт хийгдсэн. Үүнээс: төмс 23.2 га-д, хүнсний ногоо 68.6 га-д, малын тэжээл 116.24 га-д, жимс, жимсгэнэ 9.6 га-д талбайд тариалж нийт 588 тн буюу төмс 105.7 тн хүнсний ногоо 335.9 тн, малын тэжээл 149.2 тн, жимс жимсгэнэ 2.05 тн-ыг тус тус хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад тариалсан талбайн хэмжээ 40 га талбайгаар нэмэгдэн, хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 25.3% болж өмнөх оноос 2 хувиар өссөн. | -         | 71.4 |
| 4 | Аймгийн хэмжээнд ямар нэг байдлаар доройтсон, уул уурхайн олборлолтоос доройтон бохирдож, эвдэрсэн газрууд тодорхой хэмжээгээр байдал бөгөөд эдгээр газруудыг сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөсөн. | 2015-2027 | Уул уурхайн олборлолтоос доройтон бохирдсон газруудыг нөхөн сэргээсэн байна. | Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 484.4км хүнд даацын авто зам байгуулах төслийн ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 58 карьерыг хүлээлгэж өгөх хүсэлтийн дагуу ажлын хэсэг Хатанбулаг суманд очиж ажиллан 24 карьерын 134.7 га газрыг хүлээн авах акт үйлдсэн. Түмэн айл нивест ХХК, Хөх жонш ХХК, Дунфангуяна ХХК, Би ти дееволомент ХХК, Хүдэрэнт ХХК, Экилешия ХХК, Бишрээлт түшлэг ХХК, Френпишил ресурсөс ХХК, Билэгт баялаг ХХК, Хэрлэн нилгекс ХХК, Мегатек мануфактуринг Монголиа ХХК зэрэг аж ахуй нэгжүүд нийт 4.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.   | 950.0 сая | 100  |
| 5 | Хот суурингийн газрын төлөвлөлт  | 2015-2027 | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.       | Хот сууринны эдэлбэр газрын төлөвлөлтөөс аймгийн хэмжээнд 180 нэгж талбарын 22.0035 га, газрыг сумдын газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгаж сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын 2024 оны оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоолоор батлуулсан. Тухайн онд 77 нэгж талбарын 11.2875 га газрыг сумын Засаг даргын шийдвэрээр олгоод байна.   | -         | 51.3 |
| 6 | Булаг шанд-1583 га Булгийн эрүүл ахуйн бүс-887.1 га хөв цөөрөм - 2.га газар тус тус төлөвлөсөн.  | 2015-2027 | Цөв цөөрөм байгуулсан байна  | Аймгийн Засаг даргын 2012 оны А/411 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд нийт 95 хуадаг уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож дэглэмийг мөрдүүлэн ажилладаг. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 100 хувь тогтооноор ус ашиглалт, хангаалалт сайжирсан. 2024 онд Хөвсгөл сумын хүн амын ус хангамжийн Гэрлийн шанд 1-р хуадаг, Гэрлийн шанд 2-р хуадаг, Гэрлийн шанд 3-р хуадаг, Айраг, Даланжаргалан сумдад үйл ажиллагаа явуулдаг "Би Ти Дееволомент" ХХК 1 хуадаг, "Ачир" ХХК 1 хуадаг, "Сарнай дээлт" ХХК 1 хуадаг нийт 1 сум 3 компаниудын эзэмшлийн шинээр гаргасан 6 хуадагт эрүүл ахуйн бүс, 8 суманд 9 бүлгийн эхийг хашиж хангаалж тохижуулан энгийн хангаалалтын бүс тогтоож хашаажуулж, тэмдэглүүлэх ажил хийгдсэн.   | -         | 100  |

|  |                  |   |  |          |           |
|--|------------------|---|--|----------|-----------|
| <p>Газрыг хадгалан хамгаалах, экологийн тэнцлийг хадгалах зорилгоор улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтанд авах явдлыг өргөжүүлэн төлөвлөлтийн эцсийн үе шатанд улс ба орон нутгийн тусгай хамгаалалттай газар 3.7 сая га-гаар нэмэгдэхээс төлөвлөсөн</p> | <p>2015-2027</p> | <p>Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна.</p> | <p>Аймгийн хэмжээнд 2021 онд 120148.7га, 2022 онд 52290.27 га, 2023 онд 64.83 га, 2024 онд 9148.9 га нийт 2223769.9 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 20.3 хувийг газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлсэн. Аймгийн хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалтад авч, Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээллийн санд орон нутгийн тусгай хэрэгцээний газрын ангиллаар нийт 2223769.9 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 20.3 хувийг бүртгүүлсэн. Үүнээс Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 21/04 тогтоолоор 9148.9 га газрыг байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтад авч, бүртгүүлсэн.</p> | <p>-</p> | <p>60</p> |
|--|------------------|---|--|----------|-----------|